

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА- 2024\260\НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН УГТААЛЦАЙДАМ СУМЫН ХҮҮХДИЙН  
ЦЭЦЭРЛЭГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: [byambatsogtj@audit.gov.mn](mailto:byambatsogtj@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: [rsamongolia@gmail.com](mailto:rsamongolia@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

- 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
  - 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
    - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
    - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
    - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
    - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
  - 4. Аудитын тайлан .....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
- 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

Ажлын үнэмлэх № 01/148  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТӨВ АЙМГИЙН УГТААЛЦАЙДАМ  
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Л.ЦЭРЭННАДМИД ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Угтаалцайдам сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 8 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 83,2 хувиар хэрэгжүүлсэн байна

### Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт дунд

### Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	өмнөх он	тайлант он
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	72,710,723.60	172,188,663.07
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	19,274,792.60	118,872,980.21
8	Банкинд байгаа бэлэн мөнгө	19,274,792.60	118,872,980.21
9	Төгрөг	19,274,792.60	118,872,980.21
10	Төрийн сангийн харилцах	19,274,792.60	118,872,980.21
27	АВЛАГА	-	742,418.86
28	Ажиллагсадтай холбогдсон авлага	-	76,468.86
34	Бусад авлага	-	665,950.00
36	Хувь хүмүүсээс авах авлага	-	665,950.00
60	БАРАА МАТЕРИАЛ	53,435,931.00	52,573,264.00
61	Түүхий эд материал	42,078,914.00	50,115,264.00
62	Тусгай зориулалттай материал	42,078,914.00	50,115,264.00
66	Хангамжийн материал	11,357,017.00	2,458,000.00
67	Бичиг хэргийн материал	-	20,000.00
70	Түлш шатах тослох материал	2,077,500.00	-
72	Хүнсний материал	9,279,517.00	2,438,000.00
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	328,000,263.86	295,609,032.25
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	328,000,263.86	295,609,032.25
108	Биет хөрөнгө	316,186,263.86	283,795,032.25
109	Барилга, байгууламж	338,252,701.61	338,252,701.61
110	Хуримтлагдсан элэгдэл	(61,912,205.90)	(78,343,978.22)
113	Машин, тоног төхөөрөмж	51,854,452.00	48,419,452.00
114	Хуримтлагдсан элэгдэл	(25,947,314.90)	(33,776,317.62)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	45,789,034.16	31,721,567.16
116	Хуримтлагдсан элэгдэл	(32,694,403.11)	(23,322,392.68)
122	Бусад үндсэн хөрөнгө	844,000.00	844,000.00
126	Биет бус хөрөнгө	11,814,000.00	11,814,000.00
127	Програм хангамж	150,000.00	150,000.00
128	Хасагдуулга	(150,000.00)	(150,000.00)
129	Бусад биет бус хөрөнгө	11,814,000.00	11,814,000.00
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	400,710,987.46	467,797,695.32
138	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	(0.00)	6,200.00
139	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	(0.00)	6,200.00
164	Өглөг	(0.00)	6,200.00
165	Ажиллагчидтай холбогдсон өглөг	(0.00)	(0.00)
166	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	6,200.00
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	400,710,987.46	467,791,495.32
215	Засгийн газрын хувь оролцоо	400,710,987.46	467,791,495.32
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/	68,657,009.58	68,657,009.58
217	Өмч: -Төрийн өмч	68,657,009.58	68,657,009.58
223	Хуримтлагдсан үр дүн	207,919,380.70	274,999,888.56
224	Өмнөх үеийн үр дүн	207,919,380.70	207,919,380.70
225	Тайлант үеийн үр дүн	-	67,080,507.86
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	124,134,597.18	124,134,597.18
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН	400,710,987.46	467,797,695.32

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	өмнөх он	тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	554,230,450.00	685,627,600.00
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,920,850.00	-
77	Нийтлэг татварын бус орлого	2,700,400.00	-
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,700,400.00	-
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,700,400.00	-
99	Тусламжийн орлого	220,450.00	-
100	Хандив тусламж /дотоод/	220,450.00	-
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	72,379,400.00	685,627,600.00
112	Улсын төвлөрсөн төсвөөс	-	664,626,500.00
113	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	664,626,500.00
119	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	478,930,200.00	-
122	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,497,300.00	-
126	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	18,497,300.00	-
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	53,882,100.00	21,001,100.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	53,882,100.00	21,001,100.00
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	577,020,219.61	617,389,136.72
148	УРСГАЛ ЗАРДАЛ	577,020,219.61	617,389,136.72
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	557,894,077.61	617,380,616.10
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	382,254,511.10	424,357,575.90
151	Цалин	304,606,398.96	283,262,577.33
152	Нэмэгдэл цалин	71,363,763.05	137,532,241.73
154	Урамшуулал	6,284,349.09	3,562,756.84
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,416,321.30	57,243,567.55
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	30,598,437.39	44,618,227.96
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,547,007.06	3,164,584.85
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,820,825.48	2,522,867.88
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	669,799.73	630,717.21
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	6,780,251.64	6,307,169.65
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,425,118.00	21,551,779.46
165	Гэрэл цахилгааны зардал	3,034,255.00	7,006,911.28
166	Түлш, халаалтын зардал	9,230,863.00	11,440,468.18
167	Цэвэр, бохир усны зардал	4,160,000.00	3,104,400.00
170	Хангамж, бараа материалын зардал	3,621,475.00	4,039,650.00
171	Бичиг хэргийн материал	1,194,200.00	1,549,600.00
172	Тээвэр, шатахууны зардал	2,427,275.00	2,490,050.00
181	Нормативт зардал	46,580,100.00	67,905,217.00
182	Эм	305,500.00	-
183	Хоол	45,181,300.00	66,025,067.00
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,093,300.00	1,880,150.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	2,252,540.00	2,415,900.00
189	Урсгал засвар	2,252,540.00	2,415,900.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,252,000.00	1,135,000.00
200	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	1,252,000.00	1,135,000.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	61,092,012.21	38,731,926.19
210	Бараа үйлчилгээний бусад зардал	28,127,147.80	5,275,900.00

211	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	358,600.00	2,008,700.00
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,606,264.41	31,447,326.19
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,126,142.00	8,520.62
228	Бусад урсгал шилжүүлэг	18,143,800.00	-
235	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18,143,800.00	-
242	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	982,342.00	8,520.62
245	Төвлөрүүлэх шилжүүлэг	982,342.00	8,520.62
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(22,789,769.61)	68,238,463.28
269	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	36,500.01	665,950.00
271	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	36,500.01	665,950.00
276	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	1,823,905.42
277	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1,823,905.42
287	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	36,500.01	(1,157,955.42)
288	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(22,753,269.60)	67,080,507.86

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	өмнөх он	тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	551,309,600.00	685,627,600.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	551,309,600.00	685,627,600.00
111	Улсын төвлөрсөн төсвөөс	-	664,626,500.00
112	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	664,626,500.00
118	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	478,930,200.00	-
121	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,497,300.00	-
125	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	18,497,300.00	-
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	53,882,100.00	21,001,100.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	53,882,100.00	21,001,100.00
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	530,967,807.40	586,029,412.39
148	УРСГАЛ ЗАРДАЛ	530,967,807.40	586,029,412.39
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	511,841,665.40	586,020,891.77
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	382,254,511.10	428,314,476.62
151	Үндсэн цалин	304,606,398.96	282,485,288.14
152	Нэмэгдэл	71,363,763.05	134,572,969.08
154	Үр дүнгийн урамшуулал	6,284,349.09	11,256,219.40
157	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	44,416,321.30	53,363,135.69
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	30,598,437.39	37,317,098.04
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,547,007.06	4,068,889.43
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,820,825.48	3,228,671.39

161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	669,799.73	792,316.89
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	6,780,251.64	7,956,159.94
164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	18,502,618.00	20,492,579.46
165	Гэрэл цахилгааны зардал	3,034,255.00	6,443,159.02
166	Түлш, халаалтын зардал	11,308,363.00	10,792,920.44
167	Цэвэр, бохир усны зардал	4,160,000.00	3,256,500.00
170	Хангамж, бараа материалын зардал	103,500.00	-
171	Бичиг хэрэг	103,500.00	-
181	Нормативт зардал	49,817,300.00	60,207,900.00
183	Хоол, хүнс	49,817,300.00	60,207,900.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	3,493,740.00	500,000.00
189	Урсгал засвар	3,493,740.00	500,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,257,875.00	1,134,600.00
200	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,257,875.00	1,134,600.00
208	Бараа үйлчилгээний бусад зардал	11,995,800.00	22,008,200.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	10,301,675.00	18,604,300.00
210	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	1,694,125.00	3,403,900.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,126,142.00	8,520.62
225	Бусад урсгал шилжүүлэг	18,143,800.00	-
232	Хөдөө орон нутагт тогвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18,143,800.00	-
239	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	982,342.00	8,520.62
242	Төвлөрүүлэх шилжүүлэг	982,342.00	8,520.62
250	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	20,341,792.60	99,598,187.61
261	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,067,000.00	-
262	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,067,000.00	-
263	Дотоод эх үүсвэрээр	1,067,000.00	-
275	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,067,000.00	-
278	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,067,000.00)	-
303	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	19,274,792.60	99,598,187.61
304	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	(0.00)	19,274,792.60
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19,274,792.60	118,872,980.21

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
0	ДАНС	511	51300	51210+51220	
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	68,657,009.58	124,134,597.18	207,919,380.70	400,410,987.46
10	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	68,657,009.58	124,134,597.18	207,919,380.70	400,410,987.46
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	68,657,009.58	124,134,597.18	207,919,380.70	400,410,987.46
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			67,080,507.86	67,080,507.86
18	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	68,657,009.58	124,134,597.18	274,999,888.56	467,791,495.32

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	19,274,792.60	(19,274,792.60)	0
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	714,785,300.00	576,786,391.77	137,998,908.23	80.69
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	714,785,300.00	576,786,391.77	137,998,908.23	80.69
4	Бараа, үйлчилгээний зардал	714,785,300.00	576,786,391.77	137,998,908.23	80.69
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамши	525,374,100.00	428,314,476.62	97,059,623.38	81.53
6	Үндсэн цалин	338,570,200.00	282,485,288.14	56,084,911.86	83.43
7	Нэмэгдэл	171,604,700.00	134,572,969.08	37,031,730.92	78.42
9	Урамшуулал	15,199,200.00	11,256,219.40	3,942,980.60	74.06
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,671,700.00	53,363,135.69	12,308,564.31	81.26
12	Тэтгэврийн даатгал	44,657,000.00	37,317,098.04	7,339,901.96	83.56
13	Тэтгэмжийн даатгал	5,253,700.00	4,068,889.43	1,184,810.57	77.45
14	ҮОМШӨ ний даатгал	4,202,900.00	3,228,671.39	974,228.61	76.82
15	Ажилгүйдлийн даатгал	1,050,900.00	792,316.89	258,583.11	75.39
16	Эрүүл мэндийн даатгал	10,507,200.00	7,956,159.94	2,551,040.06	75.72
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,384,100.00	20,492,579.46	9,891,520.54	67.45
18	Гэрэл цахилгаан	6,715,500.00	6,443,159.02	272,340.98	95.94
19	Түлш, халаалт	20,409,700.00	10,792,920.44	9,616,779.56	52.88
20	Цэвэр, бохир ус	3,258,900.00	3,256,500.00	2,400.00	99.93
30	Нормативт зардал	69,712,600.00	60,207,900.00	9,504,700.00	86.37
32	Хоол, хүнс	69,712,600.00	60,207,900.00	9,504,700.00	86.37
34	Эд хогшил худалдан авах	500,000.00	500,000.00	-	100.00
38	Урсгал засвар	500,000.00	500,000.00	-	100.00
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,134,600.00	1,134,600.00	-	100.00
49	Мэдээллийн технологийн зардал	1,134,600.00	1,134,600.00	-	100.00
53	Бараа үйлчилгээний бусад зардал	22,008,200.00	12,773,700.00	9,234,500.00	58.04
54	Бараа үйлчилгээний бусад зардал	18,604,300.00	9,369,800.00	9,234,500.00	50.36
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,403,900.00	3,403,900.00	-	100.00
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮС	695,510,600.00	685,627,600.00	9,883,000.00	98.58
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	664,626,500.00	664,626,500.00	-	100.00
99	Улсын төсвөөс санхүүжих	664,626,500.00	664,626,500.00	-	100.00
103	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮ	30,884,100.00	21,001,100.00	9,883,000.00	68.00
104	Орон нутгийн төсвөөс	30,884,100.00	21,001,100.00	9,883,000.00	68.00
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	19,274,792.60	(19,274,792.60)	0.00
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	118,872,980.21	(118,872,980.21)	0.00
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	29.00	28.00	1.00	96.55
134	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
135	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	-	100.00
136	Үйлчлэх ажилтан	12.00	11.00	1.00	91.67
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	29.00	28.00	1.00	96.55
134	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
135	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	-	100.00
136	Үйлчлэх ажилтан	12.00	11.00	1.00	91.67

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Угтаалцайдам сумын Хүүхдийн цэцэрлэг нь сургуулийн өмнөх насны хүүхдийг бие бялдар оюун ухаан нийгэмшихүй хөгжлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 оныг "Ёс зүйн харьцаа хандлагыг дээшлүүлэх" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 8 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 80,7 хувиар биелүүлж ажилласан байна.

Тус цэцэрлэг нь 28 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт *үр нөлөөтэй* байна.

2023 он 11 сард аймгийн засаг даргын нэрэмжит үзлэг шалгалт хамрагдсан. 86,2 хувьтай үнэлэгдсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах *шаардлагагүй* гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Угтаалцайдам сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023. оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт

байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 67,086.7 мянган төгрөгөөр буюу 14,3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>Мөнгөн хөрөнгө</b>	19,274.7	118,872.9	99,598.1
<b>Авлага</b>		742.4	742.4
<b>Урьдчилгаа</b>			
<b>Бараа материал</b>	53,435.9	52,573.2	862.6
<b>Үндсэн хөрөнгө</b>	328,000.2	295,609.0	-32,391.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>400,710.9</b>	<b>467,797.6</b>	<b>67,086.7</b>
<b>Өр төлбөр</b>		6.2	6.2
<b>Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/</b>	400,710.9	467,791.4	67,080.5
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>400,710.9</b>	<b>467,797.6</b>	<b>67,086.7</b>

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны жилийн эцэст мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 118,872.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 99,597.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь урд оны төсвийн гүйцэтгэлийн үлдэгдэл, мөнгөн хөрөнгө дансанд орж ирснээс шалтгаалан өссөн байна.

Авлаг дансны үлдэгдэл 742.4 мянган төгрөг байгаа нь хувь хүнээс авах авлагатай холбоотой.

Бараа материал дансны үлдэгдэл 295,609.0 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 862.9 мянган төгрөгөөр буурсан нь хүнсний үлдэгдэл ихтэй байсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 295,609.0 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 32,391.2 мянган төгрөгөөр буурсан нь Угтаалцайдам сумын ИХТ-н 2023 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 03 тоот тогтоолоор тоног төхөөрөмж 3,435.0 мянган төгрөг, тавилга 14,947.4 мянган төгрөг нийт 18,382.4 мянган төгрөгийн хөрөнгө акталснаас шалтгаалан буурсан байна.

Өглөг данс 6.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь бараа материалын үнийн зөрүүнээс үүдэлтэй.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 683,901.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 30,884.1 мянган төгрөг нийт зарлагыг 714,785.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 714,785.3 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 714,785.3 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 683,901.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 30,884.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 576,786.4 мянган төгрөг буюу 80,7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 137,998.9 мянган төгрөгөөр, үүнээс цалин хөлс болон нэмэгдлийг 97,059.6 мянган төгрөгөөр, хоол хүнс 9,504.7 мянган төгрөгөөр, бүх төрлийн даатгалын зардлаас 12,308.5 мянган төгрөг, төрийн өмчийн байр ашиглалтын зардлаас 9,883.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 9,243.5 мянган төгрөг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	71801-Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,701.9	1,701.9		100%
2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	67,930.6	60,207.9	7,722,7	88,6%
3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	4,308.0	4,308.0		100%
4	81823-Багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	1,701.9	1,701.9		100%
5	81832 Явуулын багшийн үйлчилгээ	12,798.1	2,212.6	10,585.5	17,3%
6	81834 Боловсролын стандарт	412,761.8	372,125.8	40,636.0	90,1%
7	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	163,424.2	122,770.1	40,654.1	75,1%
8	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	30,884.1	20,992.6	9,891.5	67,9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Хүүхдийн цэцэрлэг нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

**3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	/мянган төгрөгөөр/		
				Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71801-81605	2023-12-31	Эрүүл мэндийг дэмжих	100%	1,701.9	1,701.9
2	71801-81807	2023-12-31	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	88,1%	67,930.6	60,207.9
3	71801-81816	2023-12-31	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	100%	4,308.0	4,308.0
4	71801-81823	2023-12-31	Багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	100%	1,701.9	1,701.9
5	71801-81832	2023-12-31	Явуулын багшийн үйлчилгээ	17,3%	12,798.1	2,212.6
6	71801-81834	2023-12-31	Боловсролын стандарт	90,1%	412,761.8	372,125.8
7	71801-81835	2023-12-31	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	75,1%	163,424.2	122,770.1
8	71801-80111	2023-12-31	Тогтмол зардал	67,9%	30,884.1	20,992.6

Цэцэрлэгийн хүүхдийн хоол арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь сургуулийн хүүхдийн улирлын амралттай холбоотойгоор хүүхдийн ирц багасдагтай холбоотойгоор хэмнэгдсэн. Явуулын багшийн үйлчилгээ арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь хүүхдийн ирц хангалтгүй байснаас шалтгаалан хэмнэгдсэн байна. Сургалтын хэвийн үйл ажиллагаа арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь үр дүнгийн урамшууллыг багасгаж хувь бууруулж өгсөнтэй холбоотой. Төрийн өмчийн барилгын тогтмол зардал арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь өөрийн байр ашиглалтад ороогүй, 4 бүлэг гадуур түрээсийн байранд үйл ажиллагаагаа явуулж байгаатай холбоотой.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Цахим дэлгүүрээс худалдан авалт байхгүй. 3 удаа тендер зарласан боловч оролцогч байхгүйн улмаас шууд худалдан авалт хийсэн. Мөн Монгол Шуудан ХХК, НИК, Юнител ХХК, Скайтел ХХК зэрэг аж ахуйн нэгжүүдтэй шууд гэрээтэй. Худалдан авах ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг батлуулж зохих хууль, журмын дагуу гүйцэтгэсэн.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Угтаалцайдам сумын төвийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах ажиллагчидтай холбоотой авлагыг барагдуулах, дансны үлдэгдлийг улирал, жилийн санхүүгийн эцэст баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн аудитор Б.Мягмар, аудитор С.Дашдондог, нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймгийн Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 510,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 10,200.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8,200.0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төв аймгийн Угтаалцайдам сумын Хүүхдийн цэцэрлэг нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан ажилласан байна.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэн ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорхи хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 97,060.0 мянган төгрөгөөр
- Байр ашиглахтай холбоотой болон эд хогшил худалдан авах зардлыг 9,891.5 мянган төгрөгөөр
- Нормативт зардлыг 9,505.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хөтлөлтийг шалгахад 2023 онд тус эрүүл мэндийн төв нь 159 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 150 мэдээллийг байршуулж 9 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3 “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хууль, журмын заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн ба өмнөх аудитаар өгсөн алдаа зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Угтаалцайдам сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нийт 9,279.5 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах зөвлөмж өгч ажиллаа. Завсрын аудитын зөвлөмжийн биелэлтийг жилийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 1 зөвлөмж хэрэгжиж 1 зөвлөмж хэрэгжээгүй тул аудитын тайланд зөрчлөөр орууллаа.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон албан шаардлага, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
<b>Акт</b>					
<b>Албан шаардлага</b>					
<b>Зөвлөмж</b>	1	901.1	1	901.1	100
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>901.1</b>	<b>1</b>	<b>901.1</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц зүйл ажиглагдсангүй.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,946.4 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 9,946.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоов.

#### 5.1 Төлбөрийн акт

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Шалгалтаар 9,279.5 мянган төгрөгийн хүнсний материал илүү нөөцөлсөн зөрчил илэрсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төсөвлөж зарцуулах”, 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “нөөцлөх шаардлагагүй бараа материалыг үр ашиггүйгээр удаан хадгалах шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа материал нөөцлөхгүй” заалтуудыг “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. .

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн үр ашиггүйгээр түргэн муудах бараа материалыг нөөцөлсөн тул төлбөрийн акт тогтоов.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Шалгалтаар 666.9 мянган төгрөгийн хүнсний материал дутагдсан зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хөтлөх, ажил гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах”, заалт, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн бараа материалыг дутаасан буруутай этгээдээр төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

#### 5.2 Албан шаардлага

#### 5.3 Зөвлөмж

Дээрх төлбөрийн актын биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хүнсний материал илүү нөөцөлсөн	1	9,279.5	1	9,279.5								
Хүнсний материал дутаасан	1	666.9	1	666.9								
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>9,946.4</b>	<b>2</b>	<b>9,946.4</b>								

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган

төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд 159 мэдээлэл оруулахаас 149 мэдээллийг хугацаанд нь мэдээлж 10 мэдээлэл хоцроож байршуулсан байна.	1							
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)